



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 1.2, 4.1, 4.2 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч:

Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

Д.Дэлгэрмаа

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Г.Туул

Дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хянан баталгаажуулсан тайланг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор үнэлгээний багт хүргүүлэхийг нэгжийн дарга нарт даалгасугай.

3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэж Даргын зөвлөлд танилцуулахыг үнэлгээний багт даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ